



ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

2018.08.17, БААСАН ~ №161 (960)

~ СОЁЛТ ХҮНИЙ ӨГЛӨӨ СОНИН УНШИХААС ЭХЭЛДЭГ ~

ҮНЭ: 1000Т

Аргентин бодлогын хүүгээ 45 хувьд хүргэлээ

Үүнээс өмнө ч тус улс мөнгөний бодлогын хамгийн өндөр хүүг тогтоогоод байсан юм. >3

FT FINANCIAL TIMES-ИЙН ШИЛДЭГ НИЙТЛЭЛҮҮД

ТАНД ХҮРЧ БАЙНА >7

Жюничиро Койзуми: Би этгээд биш онцгой хүн

АНУ-тай харилцаа сайн байхын хэрээр Хятадтай харилцаа сайжирна. >4

Ts.Davaasuren: OT sat idle for 5 years after power plant permit

Review of working group on OT may include termination penalty of PSCA. >6

ОНЦЛОХ

УЛС ТӨР
Ерөнхийлөгч Х.Баттулга
 "Конрад Аденауэр сан"-гийн Герхард Валерсийг хүлээн авч уулзав.
Нийслэлийн сонгуулийн
 хорооны хоёр гишүүнийг томиллоо.
ЗГХЭГ яамдуудад сахилга, дэг
 журмыг чангатгах даалгаврын биелэлтийг шалгаж байна.
У.Бямбасүрэн: Арбитрын
 шийдвэр "Эрдэнэт"-ийн үйл ажиллагаанд нөлөөлж таарна.

ЭДИЙН ЗАСАГ
Мөнгөний нийлүүлэлт 3.2 их
 наяд төгрөгөөр өсөж, 17.2 их наяд төгрөгт хүрчээ.
Зэсийн ханш дөрвөн хувиар
 буурч, 5801 ам.доллартай тэнцлээ.
Австралийн ажилгүйдлийн
 түвшин өнгөрсөн сард зургаан жилийн доод цэгт хүрчээ.
"TOP 20" индекс 0.58 хувиар
 буурч, 19,195.92



НИЙГЭМ
Монгол Улсын малын тоо
 толгой 80 саяд хүрснийг салбарын сайд мэдэгджээ.
Төв цэвэрлэх байгууламжийн
 лагийг боловсруулж бордоо, хар шороо гарган авч байна.
Энэ сарын 25, 26-нд
 автомашины дугаарыг тэгш, сондгойгоор ялган хөдөлгөөнд оруулна.
"Багшийн цалин нэмүүлэх түр
 хороо"-ноос багш нар 09.01-нээс ажил хаяна гэж мэдэгдэв.

ДЭЛХИЙ
АНУ, БНХАУ-ын худалдааны
 хэлэлцээрийн шинэ шат эхлэх товыг Бээжин зарлав.
Гангийн тариф АНУ-ын
 үйлдвэрлэлийг аварна хэмээн Трамп мэдэгдлээ.
Италийн Ерөнхий сайд Генуяд
 гүүр нурсны хариуцлагыг зам тээврийн компанид тохлоо.
ХБНГУ иргэний бүртгэлдээ
 гурав дах буюу "заримдаг хүйс"-ийг хуульчиллаа.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

2018.08.17

☁️ | ☁️

23° | 9°

ҮҮЛШИНЭ

ЦАГ АГААРЫН ДЭГЭРЖИГҮЙ МЭДЭЭЛИЙГ 8 ДУГААР НУУРГУУЗ УНШИХАА УУ.

846580004029112 00960

Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

Хувьцаат нэрээр овоглосон хулхи компаниудыг цэгцэлнэ



Үйл ажиллагаа явуулдаггүй, мэдээллээ ил тодоор дэлгэдэггүй хувьцаат компаниудыг цэгцлэх шаардлагатай байна. Эс бөгөөд ийм төрлийн "амьгүй", ашиггүй хувьцааг иргэд худалдан авч, эд хөрөнгөө эрсдэлд оруулах, хөрөнгийн зах зээлийн нэр хүндийг унагаж магадгүй байна. >3

ЗАХ ЗЭЭЛ

Lhatoir долоон улсад бүтээгдэхүүнээ экспортолно

Г.Баярсайхан
 @bayarsaikhanZGM

“Одоогоос дөрвөн жилийн өмнө гэртээ анхны бүтээгдэхүүнээ үйлдвэрлэж байлаа. Эхнээсээ л Монголоор овоглосон олон улсын брэнд бий болгохыг зорьсон. Гэхдээ бүтээгдэхүүнээ ийм хурдан экспортод гаргана гэж огт бодоогүй” хэмээн Д.Хулан ярилаа. Д.Хулан бол гоо сайхны Lhatoir брэндийг үүсгэн байгуулагч, өдгөө компанийнхаа ерөнхий захирал, ерөнхий технологичийг хийдэг бүсгүй. Монголын хэрэглэгчдэд хэдийнэ танил болж, дотоодын

зах зээлд байр сууриа олсон тус брэнд өнгөрсөн жил олон улсын тавцанд анхлан гарсан. Одоогоор Хонконг, Тайвань, АНУ, Канадад бүтээгдэхүүнээ нийлүүлж байгаа бол удахгүй Тайланд, Австрали, Энэтхэг рүү экспортолох үүд хаалга нээгджээ.

Хамгийн сүүлд Энэтхэгийн Treasurehunt компани Lhatoir-ыг экспортолох хүсэлтээ тавьж, өдгөө яриа хэлэлцээр эцсийн шатандаа орсон байна. “2018 он бидний хувьд маш чухал жил байлаа. Өнгөрсөн жил анхны экспортоо хийсэн бол энэ жил хэд хэдэн орныг нэмсэн.

> 5

FT **Хөгжиж буй зах зээлийн экспорт тарифаас ч өмнө буурчээ**

Стив Жонсон

Энэ онд хөгжиж буй зах зээл бүхий улс орнуудын экспортын өсөлт АНУ худалдааны тариф тогтоохоос бүр өмнө эрс буурчээ.

Хөгжиж буй зах зээлийн экспорт хоёрдугаар сард жилийн өмнөх үеэс 6.5 хувийн өсөлттэй байснаа тавдугаар сард ердөө 1.8 болж буурсныг Financial Times сонин тооцооллоо. Уг тооцоог Нидерландын CPB буюу Эдийн засгийн бодлогын дүн шинжилгээний хорооны (Bureau for Economic Policy Analysis,) статистикт тулгуурлан гаргасан юм.

Тавдугаар сарын үзүүлэлт 2016 > 7

УЛС ТӨР

БЗД-т засаглалын эрх шилжих үү, үлдэх үү

П.Батбөх
 ЗГМ

2016 оны намар болсон Орон нутгийн сонгуулиар нийслэлд Ардчилсан нам ялалт байгуулсан ганц дүүрэг нь Баянзүрх. Тиймээс өнөөдөр тус нам уг дүүрэгт засаглаж, удирдлагыг барьж буй. Сонгуулийн үр дүнгээр

АН 22, МАН 19 тойрогт ялалт байгуулсан.

Мөн сонгуулийн дараа зургаан ч тойрогт маргаан гарч АН, МАН-ын аль алиных нь зүгээс шүүхэд хандаад байсан юм. Дээрх маргаантай тойргуудын дөрвийнх нь маргааныг шүүх сонгуулийн болон бусад хууль зөрчөөгүй гэсэн шийдвэр гаргаж, сонгуулиар ялалт байгуулсан

нэр дэвшигчид төлөөлөгчийн суудалдаа үлдсэн. Харин Баянзүрх дүүргийн сонгуулийн 10 болон 19 дүгээр тойрогт болсон сонгуулийн маргаан удал үргэлжилж, гурван ч шатны шүүхээс дахин сонгууль явуулах шийдвэрийг гаргаад байгаа.

> 2

MIAT MONGOLIAN AIRLINES

БЕРЛИН УЛААНБААТАР
 Нэг талдаа 1.092.900₮
 Хоёр талдаа 1.797.900₮

ФРАНКФУРТ УЛААНБААТАР
 Нэг талдаа 1.105.200₮
 Хоёр талдаа 1.765.700₮

ХҮЧИНТЭЙ ӨДРҮҮД
 8-р сарын 15-аас
 9-р сарын 30-ны хооронд

8-р сарын 14-нөөс 9-р сарын 30-ны хооронд Зөвхөн Франкфурт болон Берлинээс эхлэлтэй нислэгт 2 ширхэг тээж үнээгүй

Энэхүү хямдрал нь зөвхөн дээрхи өдрүүдэд Берлин эсвэл Франкфуртаас эхлэлтэй Улаанбаатар чиглэлийн тийз авсан тохиолдолд үйлчилнэ

333 999

АЛТ 1179.21 0.37%	ЗЭС 5801 4.02%	10-ЧИНГИС БОНД 94.50 0.14%	ХУРАЛДАЙ БОНД 108.32 0.13%	ГЭРЭГЭ БОНД 95.210 0.15%	АМ.ДОЛЛАР 2463.71	ЮАНЬ 356.47	РУБЛЬ 36.78
--------------------------------	-----------------------------	---	---	---------------------------------------	-----------------------------	-----------------------	-----------------------

Хүмүүс



Жюничиро Койзуми: Би этгээд биш онцгой хүн

Робин Хардинг

Японы хамгийн нэр хүндтэй Ерөнхий сайд асантай барьсан үдийн зоог.

Токиод үдийн зоогийг эрт барьдаг заншилтай ч Жюничиро Койзуми гуай 11.30-д уулзахыг санал болгоход “Асуудалд орлоо доо” гэж бодогдов. Тэрбээр Imperial зочид буудлын дээд давхарт тансаг зэрэглэлийн Aqua Lounge-д тусгай өрөө захиалсан байлаа. Амралтын өдрөөр энд ирсэн Япон хатагтай нар үүдний өрөөнд хөлхөлдөх агаад Ричард Гиртэй төстэй гэгддэг түүний төрх хэвээр байгаа нь надад анхааруулга мэт харагдав. Кофены ширээ тойруулан дөрвөн зөөлөн сандал тавьсан уужим өрөөнд намайг орууллаа. Би яг цагтаа ирсэн хэдий ч 2001-2006 онд Ерөнхий сайд байсан эрхэм хэдийн ирээд хүлээж байсанд эвгүйцэх сэтгэл төрсөн юм. Койзуми гуайн долгиолсон урт үс жаахан бууралтсан ч нүдэнд хоногшсон хэвээр алдсангүй.

Тэрбээр хуурайдуулан мэндлээд “Зоог барих завсар ярилцана гэж надад хэлсэн. Гэхдээ би юм идэхгүй” гэв. Сайн эхлэл лав биш. Миний зүрх огшиж, хоёр сонголт үлдлээ. Ахмад улс төрийн зүтгэлтнийг хүчээр хооллох эсвэл дэлхийн хоолны төв Токио хотод “FT-тэй уусан ногоон цай” гэдэг нийтлэл бичих. Тэрбээр над руу эмлэнгүй хараад “Би 2009 онд парламентаас гарснаас хойш өдөртөө хоёр хооллож байгаа. Өглөө, оройд. Үдийн хоол хэрэггүй” хэмээн үргэлжлүүлэв. Миний Япон хэл эзэрч, Койзуми гуай надаас зайгаа барих шиг болсон тул санаачилгыг алдах аюул тулгарав. Коктейлийн өрөө боловч хоолтой л байж таарна. Хөгжим жингэнэх зуур би Imperial-ын түшлэгтэй буйданд тухалж, одоо Токиогоос арчидаг буй 1970-аад оны өрнөдийн тохь тухь мэдрэв.

Японы дайны дараах зөвшилцлийн захиргааг төр улсыг буулгахад бусдаас нхийг хийсэн хүнд асуулт тавихад тохиромжтой суудал шиг санагдлаа. Ерөнхий сайдын хувьд Койзуми Иракт цэрэглэн орохыг дэмжсэнийг дээр цэргийн гэмт хэрэгтнүүдийг оршуулсан Ясукуни хэмээх сүмд жил бүр мөргөж байв. Тэрбээр хуучинсаг, үндсэрхэг үзлийг хөндж байсан нь эдүгээ Японы улс төрийн хамгийн хүчтэй урсгал болоод буй. Шууданг хувьчилж, зохицуулалтыг багасгах түүний алхам Японы хүнд суртлыг нураасан. Тэрбээр эрх баригч Либерал ардчилсан нам дахь уламжлалт ашиг сонирхлын бүлгүүдийг нухчин дарсан Ерөнхий сайдын албанд эрх

мэдлийг төвлөрүүлэхэд тусалжээ. Ноён Койзуми одоо засаг захиргааны шинэ сөргөлдөгч болжээ. Тэрбээр 2011 оны Фукушимагийн ослоос хойш цөмийн эрчим хүчийг эсэргүүцсэн Японы хөдөлгөөнийг тэргүүлж байна. Засгийн газар үлдсэн цөмийн хөдөлгүүрүүд аюулгүй, буцаан ажиллуулж болно хэмээн ухуулж байгаа бол ноён Койзуми үүнийг худал гэдгийг илчлэн улс орноор аялж буй. Хоолны цэс авчрахад дахиад л зүрх огшив. Хавчтай талх, үхрийн махтай гамбургер, ногооны хавчуургатай талх мэтсийг бичсэн харагдана. Койзуми гуай идэхийг хүсэж байж магадгүй авч урам зориг ажиглагдсангүй. 76 настай ч хөнгөн шингэн тэрбээр Японы урт насралтыг батлах болов уу. “Миний жин бараг өөрчлөгдөөгүй. Энэ цамцыг би 15 жил өмсөж байгаа. 15 жилийн өмнө худалдаж авсан. Багадсан зүйл алга” хэмээв.

Дөрвөлжин хээтэй цамцан дээр ягаан зангиа зүүж, цайвар саарал хослол өмсжээ. Токиогийн тогоочид чимээгүй хүлцэлд өчихийн яламд би холимог сэндиц идэхээр Койзуми гуайтай хамтарлаа. Миний эвгүйдсэнийг өлссөн мэтээр ойлгосон тэрбээр тахианы мах, ногоотой шөлийг мөн над руу дөхүүлэв. Цөмийн станцын эсрэг үнэнээсээ тэмцэхийн хамт Койзуми бол уран илтгэгч хүн. Түүний эцэг болон өвөө нь улс төрд чанагдаж, өөрөө ЛАН-ын гал тогоог дамжсан. Гэвч тэрбээр Японы хувьд шинэ маягийн улстөрч. Элвис Преслиг шүтэгч, хувийн үзэлтэй энэ хүн олон нийттэй холбоо тогтоож чаддаг ба цэмбийсэн костюм өмсөж, үсээ толийтол самнасан бусдадтай адилгүй.

Өөрийнхөө үеийн Жорж Буш, Тони Блэр нараас ялгаатай нь түүний нэр хүнд Иракаас болж унаагүй. Поп урлагт дуртайд нь гайхсан үе тэнгийнхэн нь түүнийг “weirdo” буюу гайхал хэмээн хочилдог. Гэхдээ тэрбээр үүнд баярладаг ч үгүй, гомддог ч үгүй бололтой. Койзуми гуай “Улстөрчдийн нүдэнд би этгээд харагддаг байх. Гэхдээ энгийн хүмүүст бол улстөрчид гайхал амьтад биш гэж үү. Кино, кабуки театр, сонгодог хөгжим, Элвис Преслид дуртай болохоор гайхал болчих хэрэг үү. Би зүгээр л тэдгээрт дуртай” гэсэн юм. Тэрбээр henjin хэмээх Япон үгийг сайн орчуулж өгөхийг хүссэнд “этгээд хүн” гэдэг хариулт өгснийг дурсав. Үүнд сэтгэл ханасан тэрбээр “Би бол этгээд ч биш, хачирхалтай ч биш, онцгой хүн” хэмээн ярьдаг.

Койзуми гуай этгээрт гарсандаа тааламжтай байж болох

ч 37 настай хүү Шинжирос нь эцгийнхээ үзэл бодлыг өвлөж, парламентад суугаа. Эцгийнхээ улс төрийн ур чадварыг мөн залгамжилсан тул ЛАН-ын дотор залуу Койзуми Ерөнхий сайд болох нь цаг хугацааны асуудал яригддаг аж. Жюничиро хүүгээрээ үнэхээр бахархдаг авч ирээдүйд нь оролцохыг үл хүснэ. Тэрбээр “Тэр насанд хүрсэн хүн. Би хажууд нь суучихаад зөвлөх шаардлагагүй. Шинжирос ажилч дахиад л зүрх огшив. Хавчтай талх, үхрийн махтай гамбургер, ногооны хавчуургатай талх мэтсийг бичсэн харагдана. Койзуми гуай идэхийг хүсэж байж магадгүй авч урам зориг ажиглагдсангүй. 76 настай ч хөнгөн шингэн тэрбээр Японы урт насралтыг батлах болов уу. “Миний жин бараг өөрчлөгдөөгүй. Энэ цамцыг би 15 жил өмсөж байгаа. 15 жилийн өмнө худалдаж авсан. Багадсан зүйл алга” хэмээв.

Засгийн газрыг сандаргаж буй дуулианы талаар ноён Койзуми ярихаас татгалзсан ч Абэгийн

хувьд энэ намар дахиад ЛАН-ын тэргүүнээр сонгогдоход хүндрэлтэй гэлээ. Цөмийн эрчим хүч бол түүний ярих дуртай сэдэв. “Би Ерөнхий сайд байхдаа цөмийн хөдөлгүүр хэрэгтэй гэж боддог байсан. Дараа нь долоон жилийн өмнө гуравдугаар сарын 11-нд Фукушимагийн реактор газар хөдлөлт, цунами, нурангид нэрвэгдсэн” гэв. Койзуми цөмийн эрчим хүчний талаар биечлэн судлаад хууртсанаа ойлгожээ. “Цөмийг дэмжигчид аюулгүй, хямд, хязгааргүй эрчим хүчээр хангана гэх мэтээр ярьдаг” хэмээн хэлэхдээ дуу нь чангарч байв. Тэрбээр “Энэ бүхэн худал. Би Ерөнхий сайд байхдаа цөмийн эрчим хүчнийг дэмжсэн. Миний буруу” гээд хуруугаараа ширээ тогшиход шилэн аяганууд чичирхийлнэ.

Японы компаниуд Британид

цөмийн реактор барих гэж байгааг сануулахад тэрбээр “Британи бол хэрэгтэй. Ийм өндөр үнэтэй мөртөө аюултай зүйл барьж яах нь вэ” гэсэн юм. Миний ард хаалганы бариул дуугарч, Койзуми гуай зөгчид туслахаар өндөсхийв. Бидний сэндиц ирлээ. Амт гэж авах юмгүй. Токиод Парисаас илүү амтат боов, Неаполиос илүү пицца болон хоолонд дурлагдсгй дуу алдуулам тус улсын олон гоё зүйл хийдэгсэн. Гэтэл сэндиц дээр ирэхээр нарийн амт, тансаг үнэр эрсдэлд ордог. Гадна тал нь зөөлөн мөртөө хуурай эдгээр хавчуургатай талх сүмийн цайлагын сүүлийн хоол байвал зохилтой.

Цонхоор нар тусаж эхлэхэд Койзуми хүрмээ тайлав. Японоос гадна түүнийг Иракийн эсрэг эвслийг дэмжин Жорж Буштай мөр зэрэгцэн зогсож байснаар нь мэдэх байх. Энх тайванч

үндсэн хуультай тул Япон улс байлдахгүй. Гэхдээ Койзуми Иракийг эзэлсний дараах мухардалд АНУ-д туслахаар цэргийн хүчээ илгээж, хуулийн заалтын хязгаарыг тэлсэн. Тэнд үүссэн холион бантан Буш, Блэр нарыг унагасан шиг түүнд нөлөөлөөгүйг зарим талаар дайныг хэрхэн тайлбарласнаас шалтгаалсан гэдэг. Ардчиллыг цэргийн хүчээр түгээх нь хэзээ ч Японы зорилго байгаагүй агаад түүний хэлдэг үг нь АНУ, Япон хоёр бол холбоотон гэдэг тайлбар байв.

Тэрбээр “Манай холбоотон хүнд байдалд орсон. Тэд ямар ч байсан урагшлах ёстой байв. Бид холбоотноо дэмжихгүй гэдэг бол байж болшгүй зүйл. Тэгээд нөхцөл байдал буруутсаны дараа холбоотноо орхино гэдэг Японы хувьд боломжгүй. Би одоо ч зөв гэж боддог” хэмээн өгүүлсэн юм. Түүний хэлснээр АНУ, Японы эвсэл тус улсын хувьд амин чухал бөгөөд энэ нь түүний Ясукуни сүмд очихоо зогсоох нэг шалтгаан байж магадгүй. Койзуми АНУ-ын Ерөнхийлөгч Буштай уулзах үедээ “Хэрэв та намайг Ясукунид битгий оч гэж хэллээ гэхэд би очих л болно” хэмээн тандаж асуусан аж. Харин ноён Буш инээгээд “Би хэзээ ч тэгж хэлэхгүй” гэсэн гэдэг.

Одоогийн Ерөнхий сайд Абэ 2013 оноос хойш сүмд очоогүй. Түүний хуучинсаг үзлийн талаар хөндөхөд тэр жаахан ундууцах шиг болов. “Би барууны үзэлтэн үү. Абэ сан ч бас баруунтан биш”. Тэрбээр Японыг энх тайванч үндсэн хууль нь тодорхойлдог агаад олон улсын тавианд онцгой тоглогч болгодог хэмээв. “Бид гадаадад зөвхөн хүмүүнлэгийн дэмжлэг үзүүлдэг. Цэргийнх биш. Гадаадад цэргээ байрлуулах нь одоо ч буруу зүйл үү” гэлээ.

Ноён Койзуми Хятадтай харилцаагаа сайжруулахыг дэмждэг ч АНУ-ыг нэгдүгээрт тавьдаг. “Зарим хүн биднийг АНУ-аас жаахан хөндийрч, Хятадтай ойртохыг зөвлөдөг. Гэвч АНУ-тай харилцаа сайн байхын хэрээр Хятадтай харилцаа сайжирна гэдгийг ойлгох нь маш чухал” хэмээн тайлбарлав. Хачиртай талхны хагас нь тавган дээр үлдлээ. Бидний хэн нь ч дуусгахыг хүссэнгүй. Би Ноён Койзумигээс одоо цага хэрхэн өнгөрөөж байгаа талаар асуулаа. Цөмийн эсрэг тэмцлээс гадна тэр унтаж, уншиж, кино үзэж, хөгжим сонсож байгаа гэнэ.

Зөвлөх ном байна уу гэхэд Наоки Хиакутагийн A Man Called Pigate (Дээрэмчин нэртэй хүн) роман, өнгөрсөн оны Диснейгийн мюзикл Гоо бүсгүй ба араатныг санал болгов. Энэ Койзумид л тохирох сонголт. Олон улстөрч ийм асуултын хариуд гоц ухаанаа гайхуулахыг оролдоно. Гэхдээ Койзуми л лав биш. Эцэст нь бид хоёр FT-тай барьсан үдийн зоогийг хэн төлөх дээр тэмцэлдэв. Тэрбээр зөвшөөрөхийн өмнө гайхсан зөөгчид миний зочин төлбөрийг хийнэ гэсэн юм. Тэгээд хэт идэвхтэй шүтэн бишрэгч байх вий гэсэн шиг дээд давхрын хүлээлгийн танхимыг гүйлгэн харснаа олы дунд уусан одлоо. [ZGM]

101

ТӨХӨӨРӨМЖ

ДЭЛХИЙГ ХЭРХЭН ӨӨРЧИЛСӨН БЭ?

ТУН УДАХГҮЙ

Bloomberg TV Mongolia

Зах зээл

Lhamour долоон улсад бүтээгдэхүүнээ экспортолно

Гоо сайхны бүтээгдэхүүний экспортын 90 хувийг Lhamour хийж байна

«Дөрвөн жилийн өмнө гэртээ эхлүүлсэн жижиг бизнес маань өргөжөөд, бүтээгдэхүүнээ экспортолж хэмжээнд хүрнэ гэдэг яах аргагүй онцгой амжилт. Сонирхолтой нь бүтээгдэхүүний маань хэрэглэгчид манай дистрибьютер болоод байгаа. Бүтээгдэхүүнийг өөрийн биеэр мэдэрч, бидний философийг ойлгодог болсон хүмүүс тухайн улс орондоо энэ философийг түгээж, гадаадын хэрэглэгч нар тэрүүд бүтээгдэхүүн хүргэе гэсэн үндсэн дээр дистрибьютер болж байна. Бид жилийн эцэст долоон орон руу бүтээгдэхүүнээ экспортолохор төлөвлөж байгаа» хэмээн Д.Хулан нэмж хэлсэн юм.

«Бүтээгдэхүүнээ олон улсад гаргахад ямар саад бэрхшээл тулгардаг вэ?»

«Бид Монголын гоо сайхны бүтээгдэхүүний экспортын 90 хувийг дангаараа хийж байгаа. Экспортоо бага багаар нэмэгдүүлсээр л байна. Мэдээж арьсанд шууд нөлөөлөх бүтээгдэхүүн учраас экспорт хийхийн тулд цөөнгүй бичиг баримт бүрдүүлж, олон шалгуурыг давах ёстой. Эхний экспортоо хийхийн тулд олон сарын хөдөлмөр орно.

Өнгөрсөн жил бид анхны экспортоо хийсэн бол энэ жил дистрибьютерийн уулзалтаа Улаанбаатарт анх удаа зохион байгууллаа. Энэ бол Монгол Улсыг сурталчлах нэг боломж. Хамгийн сүүлд гэхэд Энэтхэг улсаас дистрибьютер компанийн төлөөлөл ирээд байна. Ирэх жил таван орноос дистрибьютер урьж ирүүлэхээр төлөвлөсөн.

Бүтээгдэхүүнээ экспортод гаргахад хүндрэл бэрхшээл гарах нь мэдээж. Гэхдээ дийлэнх нь Монгол талаасаа байдаг. Жишээ нь, төлбөр тооцооны асуудал их хүнд. Мөн далайд гарцгүй орон учраас тээврийн зардал өндөр. Энэтхэг рүү гэхэд Монголын талаас хийсэн экспорт бараг байдаггүй. Бидний харьцаж байгаа гэвээр зуучийн компаниуд Энэтхэгт бараа нийлүүлэх ямар ч туршлагагүй. Өмнө нь Канад руу экспорт хийхэд бас л ниймэрхүү бэрхшээлтэй тулгарч байсан. Туршлагагүйгээсээ болоод эвгүй байдалд ч орж байсан удаатай. Гэхдээ хэцүү ч гэсэн бид эхлэлийг нь тавих ёстой. Энэ нь дараа дараагийн хүмүүст тус



Б.Батдорж / ЗГМФ



болно.

«Танай бүтээгдэхүүн юугаараа онцлог болоод гадныхны анхаарлыг татаад байна вэ?»

«Дэлхий дахинд олон компани гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Харин бид бүтээгдэхүүнээ ямар байдлаар Монголын түүхий эдтэй хослуулах болох вэ, олон улсад жишиг болсон байгалийн гаралтай бүтээгдэхүүний трэндтэй ямар байдлаар нийцүүлэх вэ гэж их бодсон. Жишээ нь, хонины сүүлний тос, жамц давс зэрэг түүхий эдийг онцлог байдлаар оруулсан нь бидний дөрвө тал. Нөгөө талаар бүгдийг өөрсдөө үйлдвэрлэдгээрээ бусдаас ялгарна. Түүхий эд

боловсруулахаас авахуулаад эцсийн бүтээгдэхүүн гарах хүртэлх бүх шат дамжлагыг өөрсдөө хийдэг.

Анх ванны бөмбөг, саван, уруул өнгөлөгч гэсэн гурван бүтээгдэхүүнтэй байсан бол одоо 60 төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг боллоо. Манай компани 30 гаруй ажилтантай, дийлэнх нь эмэгтэйчүүд. Бид эмэгтэйчүүдийг өөрийн гэсэн ажил, зорилго, мөрөөдөлтэй болгоход туслахыг хичээдэг. Тиймээс оксид чиглэсэн хөтөлбөрийг байнга зарладаг. Мөн эмэгтэйчүүдийн гарааны бизнесийг дэмжихэд их анхаардаг. Манай дистрибьютерууд ихэвчлэн гарааны бизнес

эрүүлжүүлэх бүтээгдэхүүн гэж ойлгож болно. Манай түүхий эдийн хослол маш сонирхолтой. Жишээ нь халгай, ганга, сарлагийн сүүг нэрлэж болно. Саванг цэвэр сарлагийн сүүгээр хийснээр арьсны архаг өвчтэй хүмүүс ч хэрэглэх боломжтой болсон.

Одоо харшил гэдэг зүйл дэлхийн бүх л улс оронд эрс нэмэгдэж байна. Харшилтай хүмүүс гоо сайхны бүтээгдэхүүн тэр бүр хэрэглэж чаддаггүй. Харин бид харшилтай хүмүүст зориулаад өнгөгүй, үнэргүй бүтээгдэхүүн хийж байгаа. Арьсыг эрүүлжүүлж, дотроос нь эрүүл болгоно гэсэн үг.

«Бүтээгдэхүүнийгээ орцыг хэрхэн татаж авдаг нь сонирхол татаж байна?»

«Би олон улсын органик гоо сайхны химийн найрлагын дипломтой. Англи улсад энэ чиглэлээр суралцаж төгссөн юм. Органик гоо сайхны бүтээгдэхүүнд химийн бодис ороогүй болохоор хэдэн юм хооронд нь нийлүүлээд болчихно, амархан ажил гэж хүмүүс боддог. Гэхдээ энэ бол олон улсын стандарттай бүхэл бүтэн шинжлэх ухаан. Монгол шиг ийм сайхан баялаг оронд асар их нөөц бий. Олон жилийн турш уламжлан хэрэглэж байсан зүйлийг л манай компани орчин үеийн хэрэглээ болгож өгч байгаа юм.

«Зах зээлд өрсөлдөхөд үнэ чухал нөлөө үзүүлнэ. Танай бүтээгдэхүүний үнийг сонирхож болох уу?»

«Анх үйлдвэрлэлээ эхлэхэд хүмүүс “Жирийн нэг саван яагаад

Гоо сайхны гэхээсээ илүү эрүүлжүүлэх бүтээгдэхүүн гэж ойлгож болно

хийж эхэлсэн эмэгтэйчүүд.

Манайх эрэгтэй, эмэгтэй, хөгшин, залуу, хүүхэд гээд бүх хүнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Эрүүл мэндэд тустай бүтээгдэхүүн гэдэг нь хамгийн гол онцлог. Өөрөөр хэлбэл, гоо сайхны гэхээсээ илүү

Самридди Пандей: Lhamour Энэтхэгт амжилт олж чадна

Lhamour брэндийг эх орондоо нийлүүлэхээр яриа хэлэлцээ өрнүүлж буй Энэтхэгийн Treasurehunt компанийн захирал Самридди Пандей Монголд ирээд байна. Түүнээс зарим зүйлийг тодрууллаа.

«Яагаад Монголын бүтээгдэхүүнийг эх орондоо борлуулахаар шийдсэн юм бэ. Юу нь илүү таалагдав?»

«Өнгөрсөн жилийн арванхоёрдугаар сараас Lhamour-ыг анх мэддэг болсон. Ах маань Сингапурт зочлоод буцахдаа Lhamour-ын бүтээгдэхүүнийг гэр бүлийнхэндээ бэлэг болгон авчирсан юм. Ахын эхнэр гарын тос, биеийн тосыг нь хэрэглэж үзэхэд маш их таалагдсан юм билээ. Ингээд гэрийнхэндээ хэлсэн. Үүнээс хойш Lhamour-ын бүтээгдэхүүнийг судалж, анх бий болсон түүхийг уншаад Энэтхэгийн хэрэглэгчдэд

хүргэхийг хүссэн юм.

Бид багаасаа байгальд ээлтэй байх, байгалийн гаралтай бүтээгдэхүүн хэрэглэхийн үнэ цэнийг мэдэрч өссөн хүмүүс. Lhamour-ын түүх болон үнэ цэнэ бидэнд гүн сэтгэгдэл төрүүлсэн. Тиймээс энэ бүтээгдэхүүнийг Энэтхэгт түгээх бизнес эрхлэхээр шийдсэн юм.

«Компанийнхаа талаар сонирхуулаач?»

«Манай гэр бүлийнхэн бүгд дор бүрнээ ажил хийдэг байлаа. Харин Lhamour-ын талаар мэдсэний дараа гэр бүлээрээ гарааны бизнес эхлүүлэхээр шийдэж энэ компани байгуулсан юм.

«Энэтхэг бол тэрбум гаруй хүн амтай асар том зах зээл. Lhamour брэнд танай зах зээлд хэр амжилт олох бол?»

«Амжилт олох магадлал маш өндөр гэж бодож байгаа. Яагаад гэвэл зөвхөн Энэтхэг гэлтгүй

дэлхий нийтээрээ байгалийн гаралтай бүтээгдэхүүнийг илүүд үзэж байна. Энэтхэгт маш олон байгалийн гаралтай бүтээгдэхүүн байдаг. Манай улсын олон бүсгүй өөрсдийн гарааны компани байгуулаад явж байна. Ерөнхийдөө байгалийн гаралтай бүтээгдэхүүний ач холбогдлыг сайн ойлгодог болсон. Гэхдээ байгальд ээлтэй, өөрийн гэсэн үнэ цэнэтэй компанийг сонгох хандлага давамгайлж байгаа. Тиймээс Lhamour зах зээлд байр сууриа олж чадна гэж бодож байна.

«Жирийн хэрэглэгчийн хувьд асуухад Lhamour-ын ямар бүтээгдэхүүн илүү таалагдав?»

«Чацарганатай биеийн тосыг хамгийн их хэрэглэдэг. Энэтхэгийн цаг агаарт нийцдэг болохоор миний арьсыг их гоё болгосон.



ийм үнэтэй байгаа юм” гэх мэтээр асуудаг байсан. Харин одоо бол манай байнгын хэрэглэгч нар “Дэндүү хямдхан санагдаж байна. Ийм бүтээгдэхүүнийг гадаадаас хэзээ ч ийм үнээр олж чадахгүй” гэдэг. Олон улсад бол манай бүтээгдэхүүн яг боломжийн үнэтэй, айхтар өндөр биш, бас хямдхан биш. Гар аргаар үйлдвэрлэдэг гэдэг утгаараа бүтээгдэхүүн бүр өөр. Нэг төрлийг цөөн тоогоор хийдэг, массын үйлдвэрлэл биш болохоор жирийн бүтээгдэхүүнийг бодвол арай үнэтэй. Гэхдээ гар аргаар хийсэн гэдэг нь бидний бас нэг үнэ цэнэ. Гар аргаар үйлдвэрлэсэн үнэ цэнэ бид хэзээ ч алдахгүй гэж боддог. Манай бүтээгдэхүүн ерөнхийдөө 5-30 мянган төгрөгийн хооронд зарагдаж байгаа.

«Та яриандаа үнэ цэнэ гэж хэд хэд дурдлаа. Компанийн үнэ цэнийн талаар илүү тодруулж өгнө үү?»

«Бидний хувьд үнэ цэнэ гэдэг зүйл анхнаасаа чухал байсан. Эрүүл бүтээгдэхүүн гэхээсээ илүү эрүүл нийгмийг бий болгохоор зорьж буй нь бидний хамгийн гол үнэ цэнэ. Lhamour-ын бүтээгдэхүүн бол бидний алсын зорилгод хүрэх хэрэгсэл юм. Бид бүтээгдэхүүнээрээ дамжуулаад өөрийгөө хайрлаж, эрүүл мэндээ анхаарал тавиарай гэсэн мессежийг хүмүүст хүргэхийг зорьж байна.

Бид одоогоор Шангри-Ла, Их дэлгүүр, Зайсан Хилл гэсэн гурван газар салбар дэлгүүрээ ажиллуулж байгаа. Борлуулалт жил ирэх тусам нэмэгдэж, байнгын худалдан авалттай болсон. Хүмүүс ихэвчлэн гэр бүлээрээ хэрэглэдэг юм. Нэг үеэ бодвол залуучууд манай бүтээгдэхүүнийг их сонгож байгаа. Бүтээгдэхүүний чанараас гадна цаад компани нь юунд тэмүүлж байна, нийгэмд ямар хэрэгтэй юм хийх гээд байгааг хүмүүс мэддэг болсон. Бид хүүхэд, залуучууд, ээжүүд, эмэгтэйчүүд рүү чиглэсэн хөтөлбөр хийдэг. Манай бизнес өргөжин тэлэх тусам эдгээр хөтөлбөрөө улам эрчимжүүлнэ. Ерөнхийдөө манай бүтээгдэхүүний үнэ цэнийг харж гаднын компаниуд холбогдож болохоор аль ч улсад зарах боломжтой гэж бодож байгаа.

Д.Хулан гадаадад цөөнгүй жил суралцсан. Монгол гэхээр гадныхан бараг мэддэггүй, Монголын брэнд гэж сонссон хүн байдаггүй нь харамсалтай санагдадаг байж. Тиймээс Монголын нэрийг олон улсад гаргасан бүтээгдэхүүн үйлдвэрлэхээр зорьж, Lhamour брэндийг бий болгосон гэдгээ тэрбээр сонирхохуулан. Түүний хувьд, зорилго эхнээсээ ийнхүү биелж, олон улсад танигдаад эхэлжээ. [ЗГМ]

ZGM DAILY

Minister of Energy expresses Mongolia's side on PSCA

The minister confirms there are no talks about termination of Baganuur power plant.

Foundation is open for cooperation in any sector.

President receives Deputy Secretary-General of Konrad Adenauer Foundation.

Monnichi.today platform launches in Mongolia

Mongolia-Japan Business forum to take place on September 17.

Top 20 Index falls 0.58 percent, to 19,195.92 points

Market cap stands at MNT 2.32 trillion.

ZGM: HIGHLIGHTS

POLITICS

Parliament Speaker Enkhbold Miyegombo meets the delegation led by Khammanh Sounvileuth, Minister of Home Affairs of the Lao People's Democratic Republic who are on a visit to Mongolia.

State Secretary of the Ministry of Foreign Affairs Davaasuren Damdinsuren receives the Ambassador Extraordinary and Plenipotentiary of the republic of Poland to Mongolia Michael Labenda on the occasion of completion of his diplomatic mission.

The 16th Mongolia-Germany Forum to be held under the theme "Democracy needs democrats: Future of Political education of Mongolia and Germany" on August 17 in Ulaanbaatar. The event is annually organized alternately in Berlin and Ulaanbaatar.

Batbold Sundui, Mayor of Ulaanbaatar, and Regdel Duger, President of the Mongolian Academy of Sciences (MAS), sign a Memorandum of Understanding on cooperation to develop the capital city based on science. According to the MoU, MAS will determine solutions for development issues of the capital city, collaborate to formulate a science-based policy for mega investment projects and provide recommendations based on scientific researches regarding the reduction of air and soil pollutions.

ECONOMY

In conjunction with the launch of Monnichi.today platform, a Mongolian business and economic integrated platform in Japanese, Mongolia-Japanese business forum announced to take place in Ulaanbaatar city on September 17, 2018.

Top 20 Index falls 0.58 percent, to 19,195.92 points. MSE A Index decreases 0.08 percent, to 9,338.02 points. MSE B Index drops 0.26 percent, to 9,217.42 points. Market cap stands at MNT 2.32 trillion.

SOCIETY

Erdenebaatar Dashdondog, an engineer of the Mazaalai Project, discloses that Mongolia is preparing to launch the second satellite at the 3rd meeting of international project BIRDS.

Transmission line to be built in flood-hit areas with the support of MNT 31 million from the Embassy of the Republic of India in Ulaanbaatar.

Reconstruction of railway line in Ulaanbaatar-Sainshand route, in which a train derailed last week, completed.

RestoEXPO 2018, an event for restaurant and hospitality enterprises to take place at Crocus Event Hall on September 17-19. Scan the QR code for further information.



Ts.Davaasuren: OT sat idle for 5 years after power plant permit

Review of working group on OT may include termination penalty of PSCA

B.Tugsbilig
@tugsbiligZGM

Earlier this week, the Minister of Energy Davaasuren Tserenpil gave an interview to a local media outlet "iToim.mn" on recent scandalous deals in the energy sector, including the Power Sector Cooperation Agreement (PSCA) with Oyu Tolgoi, and expressed Mongolia's position on them.

-Will the Government renegotiate Eastern Energy System agreement? Why was the contracted get terminated?

-The agreement violated the article 7.3 of the Investment Agreement, which states to draw electricity from the territory of Mongolia within four years of operation. In other words, the Parliament-consented agreement was hard to amend for the Cabinet without having to negotiated with the Parliament. Thus, the agreement was terminated. Arnaud Soirat, Chief executive of Copper and Diamonds of Rio Tinto Group, said some uncanny remark that the company will establish the plant if the Cabinet issues a demand to draw electricity domestically within four years. That mister still do not understand the Investment Agreement. They accepted that responsibility under the investment Agreement. They were obliged to draw electricity within four years after commencing operations due in 2017. I do not



Batdorj.B / ZGM©

understand what this mister meant by "issuing a demand".

Generators with over 240MW cannot be installed in Mongolia

-It seems that the location of the

power station is currently under discussion?

-I am curious about that. They received a 5-years permission to build the station at the mine from our ministry in July 2012. The permit was expired in 2017. Nothing has been done within that period. They should stop playing with the Government of Mongolia. They did not lift a finger before the Southern Region Power Sector Cooperation Agreement. The 2014 Tavan Tol-

goi negotiation was also the same. Therefore, the Cabinet decided to terminate the contract.

-Will the Tavan Tolgoi coal-fired power station project continue?

-The Parliament and Cabinet expressed their position that Mongolia will build the power plant based on Tavan Tolgoi residual coal deposits. It is up to them to select the three options proposed through the Investment Agreement.

-Although Oyu Tolgoi prom-

ised to draw power from Mongolia within four years after commencing operations, they violated the agreement. Will they be held accountable for that?

-The Government established a working group on some issues concerning high loan interest, tax act and violation of investment agreement. The group may report their review on that.

-What about Baganuur power station? Are there are talks on terminating the agreement? There are rumors that the Government will go under MNT 512 billion debt if the contract is terminated.


-As for the compensation, there are talks about potential risks with that amount. It does not mean we are obliged to pay them. The thing is, some compensation may come up after the contract termination. It does not mean the power station's high technology is not incompatible to Mongolia. They are planning to install high-capacity generator that are not suitable for Mongolia's system. Generators with over 240MW cannot be install in Mongolia. Because we manage our system by drawing 240MW power from the Russian Federation. We will not be able to manage higher generators. The contract was negotiated regardless of the incompatibility. We demanded the investors to install a system compatible with Mongolia. We did not discuss any termination of contract.

-Democratic Party's group in the Parliament made a statement demanding the Cabinet's dismissal. What is your position on this?


-Cabinet penalized the related officials regarding the issues around the Ministry of Road and Transport Development. The officials themselves resigned from their position, acknowledging their responsibility. [ZGM]

FX MARKET


USD/MNT rate (One month to date)



RUB/MNT rate (One month to date)



CNY/MNT rate (One month to date)



German political foundation delegate pays courtesy call on President Battulga

President of Mongolia Battulga Khaltmaa received Dr. Gerhard Wahlers, Deputy Secretary-General and Head of the European and International Cooperation Department of the Konrad Adenauer Foundation, who is paying a working visit to Mongolia yesterday.

The Konrad Adenauer Foundation, a German political party foundation, opened its office in Mongolia in 1993, and this year marks the 25th anniversary of bilateral cooperation.

At the beginning of the meeting, Dr. Gerhard Wahlers thanked the President for the audience, and expressed his satisfaction with the Konrad Adenauer Foundation's successful cooperation with Mongolia for the last 25 years during which the organization co-implemented numerous projects and programs and supported Mongolia's democratic process.

President Battulga underlined that the organization has been assisting

Mongolia's democratic reform from the beginning, and appreciated how the organization has helped train young workforce in scope of its cooperation with political parties and other organizations in Mongolia. The President also expressed his satisfaction towards the regularity of high-level visits paid between the two countries in recent years, while conveying his interest in broadening Mongolia-Germany relations with economic content.

Dr. Gerhard Wahlers affirmed that the Konrad Adenauer Foundation is open to cooperation with Mongolia in any sector, and noted that there was much to learn from Mongolia.

The sides had an elaborate discussion on political and economic issues. At the end of the meeting, President Battulga extended his greetings on the 25th anniversary of cooperation between Mongolia and the Konrad Adenauer Foundation, and wished them success. [ZGM]

ЦАХИМ ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2018 оны 08 дугаар сарын 17

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР: Архи, шар айраг нийлүүлэх
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР: МИАТ/201801088 /6/

МИАТ ТӨХК эрх бүхий тендерт оролцогчдоос **Архи, шар айраг нийлүүлэх** тухай 2 багц бүхий цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь **50,000 төгрөг**, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жилийн буюу 2016, 2017 оны борлуулалт тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байх,

2. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 40 хувиас багагүй байх,

3. Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2016, 2017 он

4. Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байх,

5. Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: шаардлагатай

Тендерийн хамт **Багц 1-д 6,860,000 төгрөгийн, Багц 2-т 5,400,000 төгрөгийн** дүнтэй тендерийн баталгаа тус тус ирүүлнэ.

Цахим тендерт оролцогч цахим баталгаа гаргах эрх бүхий арилжааны банкаар тендерийн нэг баталгаа гаргаж болох бөгөөд багц тус бүрийн баталгааны дүнг тодорхой бичсэн байх шаардлагатай.

Тендерийг **2018 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 11.00 цаг-аас өмнө** цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn/-д өөрийн аж ахуйн нэгжийн цахим гарын үсэг /PKI/-ээр нэвтрэн орж цахим хэлбэрээр ирүүлэх ба тендерийг **2018 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 11.30 цаг-т** нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй.

Дотоодны давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн мэдээллийг доорх хаягаар авч болно.

МИАТ ТӨХК, Хан-Уул дүүрэг, 10-р хороо, Буянт-Ухаа 45, МИАТ ТӨХК-ийн төв байр
Хангамж, үйлчилгээний хэлтэс 103 тоот
Утас: 70049860, факс: 70049919

Syndicated articles from
FINANCIAL TIMES

© The Financial Times Limited (2015). All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. ZGM is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.



BBM©

Хөгжиж буй зах зээлийн экспорт тарифаас ч өмнө буурчээ

Гэхдээ Capital Economics-ийн статистик CPB-гийнхээс арай гайгүй гарсан. Энэ нь оройтож тохиосон Хятадын сар шинийн баяртай холбоотой засварыг өөрөөр тооцоноос болсон байж болзошгүй. Яаж ч тооцлоо гэсэн, гурван сар тутмын дунджаар авч үзэхэд 2017 оны долдугаар сард 6.1 хувьтай байсан экспортын өсөлт жилийн өмнөх үеэс 3.5 хувиар суларсан дүнтэй байгаа юм.

Хөгжиж буй зах зээлийн өсөлт газрын тос зэрэг таваарын үнэ, Хятадын экспортоос үндсэндээ шалтгаалжээ.

гөрсөн зун хөгжиж буй зах зээлийн экспорт 2.6 нэгж үзүүлэлтээр буурсны 1.1 нэгжийг дангаар буюу даруй 40 хувийг эзэлж байна.

Австрали, Япон, Их Британи, АНУ зэрэг бусад хөгжингүй эдийн засаг уг удаашралын 0.9 нэгжтэй холбоотой. Харин БНХАУ хөгжиж буй зах зээл 1.5 нэгжээр өсөхөд үүрэг гүйцэтгэв. Хятадад эрэлт сайн байсны ачаар хөгжиж буй зах зээлийн экспорт 0.9 нэгж буюу үл ялиг өсөлттэй тэнцвэр барьжээ.

Өөр нэг тусдаа судалгаа, NN Investment Partners-ын (NNIP) статистикийг үзвэл БНХАУ-д тогтоосон АНУ-ын хоригийн эхний давалгаа, үүний эсрэг Бээжингийн хариу арга хэмжээ нь лавтай тавдугаар сар хүртэлх хугацаанд хөгжиж буй зах зээлийн экспортыг муутгах нөхцөл болж чадаагүй байна.

Нидерландын активын менежерийн тооцоо нь хөгжиж буй зах зээл бүхий 50 улсын экспортын өгөгдлийг жилийн өмнөх үетэй харьцуулсан статистикт тулгуурлажээ.

Хөгжиж буй зах зээлийн өсөлт газрын тос зэрэг таваарын үнэ,



Хятадын экспортоос үндсэндээ шалтгаалсан байна. Экспортыг хэмжээгээр нь авч үзвэл 3-5 орчим хувиар өссөн тооцоог NNIP-ийн хөгжиж буй зах зээлийн ахлах стратегич Маартен-Ян Баккум гаргалаа. Сүүлийн хэдэн жил уг үзүүлэлт 5-10 хувьтай байсантай харьцуулбал өсөлт удааширсан хэрэг болжээ.

“АНУ-ын протекционист занал статистикт илэрч амжаагүй. Одоогоор учруулсан хохирол

нь бага” хэмээн ноён Баккум анхааруулав.

Гэхдээ Европ, Япон болон дэлхийн хөгжиж буй зах зээлийн бусад хэсэг “сайн тэсэж”, энэ зах зээлийн валлоутуд саяхан суларсан нь өрсөлдөөнд дэм болно. Дээр нь Хятад орны түлхэц өгөх бодлогын ээлжит шинэ шат Латин Америк, Африкт таваар экспортлоход тулхэц өгнө хэмээн ноён Баккум тайлбарлаж байна.



► Шинэ Зеланд гадаадынханд орон сууц худалдахыг хориглов

Жэйми Смит
Шинэ Зеланд орон сууцны үл хөдлөх хөрөнгийг гадаад иргэнд худалдахыг хориглолоо. Уг хориг нь сүйрэл нүүрлэх цагт “амиа хоохойлох газар” юм уу амралтын сууц болгох үүднээс Шинэ Зеландын тансаг зэрэглэлийн үл хөдлөх хөрөнгийг булаацалдан авдаг болсон супер баячуудад цохилт өгөх зорилготой. Лхагва гарагт Шинэ Зеландын парламент баталсан шинэ хууль нь жилийн өмнө тус улсын олон нийтийг хамарсан дургүйцлийн хариуд авч буй арга хэмжээ болж байна. РауПа-ыг үндэслэгчийн нэг Питер Тиль Шинэ Зеландын харьяат болоход тавьдаг нийтлэг шаардлагад тэнцээгүйг үл харгалзан Засгийн газар иргэншил олгосон нь олны дургүйцэл төрүүлжээ.

► Германы нээлттэй банкны старт-ап 100 сая ам.доллар босгов

Олаф Шторбек
Хамбургд 2011 онд сууриа тавьсан, нээлттэй банкны (open banking) старт-ап Deposit Solutions компани 100 сая ам.долларын хөрөнгө амжилттай төвлөрүүлж зах зээлийн үнэлгээгээ 500 сая гаруй ам.долларт хүргэв. Уг ажиллагаа Германы санхүүгийн технологийн салбарын эрчимтэй хөгжлийн сүүлийн шинэ жишээ болж байна. Германы санхүүгийн технологийн салбар 2017 онд 1.7 тэрбум, энэ оны эхний хагаст 325 сая ам.долларын хөрөнгө оруулалт татаж чадсаныг их өгөгдлийн анализын EY компани тооцоолжээ. Deposit Solutions нь жижиглэнгийн банкны үйлчилгээг зээлдүүлэгчдийг холбох программ хангамж хөгжүүлдэг.

► Грекийн боловсролтой иргэд гадагш урсаж байна

Боловсролтой олон мянган иргэн гадагш явж байгаа нь Грекийн эдийн засаг ойрын хугацаанд сэргэхэд сөрөг нөлөөтэйг Афины эдийн засаг, бизнесийн их сургуулийн профессор Жорж Пагулатос анхааруулав. Грект 2010 оноос хойш, үндсэндээ 20-30 насны, 350 мянгаас 400 мянган иргэн нь ихэвчлэн Европын холбооны улсууд руу цагаачилжээ. Цагаачдын гуравны хоёр нь их сургууль болон түүнээс дээш түвшний боловсролтойг Оксфордын их сургуулийн судлаач Эммануил Працнакис тайлбарлав. Гадаадад гарсан грекчүүдийн ихэнх нь эх орондоо буцах бодолгүй байгаа юм.

Tencent-ийн хувьцааны үнэ дахин унав

Луиз Лукас
Хятадын технологийн Tencent групп нэгдүгээр сараас хойш зах зээлийн үнэлгээ нь 170 тэрбум ам.доллараар буурчихаад байгаа. Гэхдээ үүнийг үл харгалзан сүүлийн жил хагаст аль ч венчур болон шууд хөрөнгө оруулагчаас илүүгээр хөрөнгийн зах зээлээс санхүүжилт босгожээ.

Хоёрдугаар улирлын орлогоо лхагва гарагт мэдээлсэн тус компанийн хувьцааны үнэ нэгдүгээр сард оргилдоо хүрч 473.58 хонконг доллар болсноос хойш буурсаар байгаа юм. Monster Hunter: World хэмээх шинэ видео тоглоомынх нь борлуулалтыг Бээжингийн тушаалаар зогсоосны дараа Tencent зөвхөн мягмар гарагт 15 тэрбум ам.доллар алдав. Азийн хамгийн үнэтэй компани хэмээх алдар эдүгээ тус компанийн гол өрсөлдөгч Alibaba-д шилжлээ.



BBM©

Tencent-ийн хувьцааны үнэ Хонконгийн биржид лхагва гарагт дахин 3.9 хувиар унасан юм. Эцэст нь нэгж хувьцаа 336 хонконг доллар (42.80 ам.доллар) буюу 3.6 хувиар буурсан дүнтэй арилжаа өндөрлөв. Bloomberg-ийн

судалгаанд хамрагдсан шинжээч нар тус компанийн орлогыг 77.66 тэрбум юань буюу 11.2 тэрбум ам.доллар, цэвэр ашгийг нь 19.18 тэрбум юань болгон засаж тооцов. Өнгөрсөн сард тус компанийн орлогыг удаа дараа багасгаж

тоосон. Гэвч хувьцааг нь зарах зөвлөгөөг ABC International-ийн ердөө ганц шинжээч зөвлөжээ.

Tencent нь хэд хэдэн фронтод цохилт хүлээгээд байна. Орлогынх нь гол эх үүсвэр видео тоглоомын борлуулалт буурч,

Хятадын төрийн зохицуулах байгууллагын өөрчлөлттэй уялдан шинэ тоглоомд өгдөг зөвшөөрөл саагтлаа.

Технологийн салбар дахь бусад өрсөлдөгч нарт нь тохиолдсончлон Вашингтон, Бээжингийн хоорондох худалдааны дайн, валютын ханш уналт, төлбөрийн чадварт тавьж буй хатуу шаардлага ч сөрөг нөлөөлөв.

Tencent зах зээлд эзэлдэг хувиа хэвээр хадгалахын тулд бэрхшээлийг үл харгалзан мухардав. Tencent-ийн хүнсний жижиглэн худалдаа, хүргэлтийн үйлчилгээний Meituan Dianping салбар ч Alibaba-гийн харьяа Ele.me-тэй ширүүн өрсөлддөг.

Гэхдээ л Tencent 2017 он

гарснаас хойш 12 IPO-гоор 20 тэрбум ам.доллар хуримтлуулсныг SV Insights-ын судалгаанаас үзэж болно. Хайлтын хэрэглүүрийн Soigo, цахим жижиглэн худалдааны Pinduoduo-гийн IPO үүнд багтана. “Хөрөнгийн янз бүрийн эх үүсвэр үүсэж, ялангуяа Sequoia-гийн венчур капитал болон мөнгө босгох бусад өчнөөн ажиллагаа өрнөсөөр байгаа ч Tencent аль ч хөрөнгө оруулагчаас илүү олон IPO-той” хэмээн SV Insights-ын шинжээч Мэтью Вон тайлбарлав. IPO гаргах нь Tencent стратегия өөрчилж буйн илрэл хэмээн тэрбээр үзсэн юм.

Гэхдээ технологийн салбарын олон IPO зах зээлд гарсныхаа дараа тун муу үзүүлэлттэй байна. Нууа хэмээх АНУ-д бүртгэлтэй онлайн стриминг тоглоомын группийн хувьцаа л листингийн үнээсээ дээгүүр үзүүлэлттэй яваа.



Ам.доллар чангармагц зэсийн үнэ сулрав

Хэнри Сандерсон
Хөгжиж буй зах зээлд ам.долларын ханш чангарч дэлхийн эдийн засгийн өсөлтөд түгшүүр үүсэмэгц зэсийн үнэ лхагва гарагт энэ оны үнэмлэхүй түвшинд уруудлаа. Лондоны металлын биржэд нэг тонн зэс 6000 ам.доллараас доош оров. Энэ нь 2017 оны долдугаар сараас хойш тохиолдоогүй сулралт болов. Зэсийн зэрэгцээ хөнгөн цагаан, никель, цайрын үнэ мөн уналаа.

Турк лир, хөгжиж буй зах зээлийн хувьцаа суларсан нь дэлхийн гол валлоутудтай харьцах ам.доллар ханшийг сүүлийн 13 сарын үнэмлэхүй түвшинд өсгөж, америк бус хэрэглэгчдэд таваарыг үнэтэй болгов. Үүний зэрэгцээ саяхан гарсан статистик дэлхийн зэсийн 40 орчим хувийг хэрэглэгч Хятадын эдийн засаг удааширч буйг ойлгуулж өглөө. Ам.доллартай харьцуулсан юуныин ханш ч лхагва гарагт сүүлийн 17 сарын

үнэмлэхүй түвшин суларчээ. Лондонд өглөөний арилжаагаар тонн зэс 5902 ам.доллар болсон нь зургадугаар сарын үнэмлэхүй өсөлтөөс 19 хувь буурсан үзүүлэлт юм. Уг уналт FTSE 100-д багтдаг зэс олборлогчдын хувьцааны үнд ч нөлөөлөв. Antofagasta-гийн хувьцаа хоёр хувь, Glencore-ийнх 1.4 хувиар буурлаа. “Дэлхийн эдийн засгийн хэмжүүр болдог зэсийн үнэ буурсан нь сэтгэл зовоох зүйл” хэмээн AJ Bell-ийн хөрөнгө оруулалт



хариуцсан захирал Расс Моулд өгүүлж байна.

Дэлхийн зэсийн хамгийн том уурхай-Чилийн Эскондидаг зээмшигч BHP Billiton тус уурхайн гол үйлдвэрчний эвлэлтэй яриа хэлэлцээгээ үргэлжлүүлэхээр зөвшөөрсөн нь таваарын үнэ буурахад мөн нөлөөлжээ. Жилийн өмнө яриа хэлэлцээ тасарч, ажил хаялт 44 хоног үргэлжилснээс хойш хоёр тал хөдөлмөрийн шинэ гэрээ байгуулахаар чармайж байна.



Өдрийн хэмнэл

ЗУРХАЙ



Билгийн тооллын 7

Намрын тэргүүн цагаан бич сарын хоёр хар мэнгэтэй цагаагчин могой өдөр. Үс засуулбал: Хэрүүл тэмцэл ирнэ. Наран ургах, шингэх: 05.50-20.01 Барилдлага: Үл тохирох Шүтэн барилдлага: Мунхрахуй Суудал: Уул

Аргын тооллын наймдугаар сарын 17, Сугар гараг. Билгийн тооллын 7, Салхины эх одтой, цагаагчин могой өдөр.

Өдрийн наран 05.50 цагт мандаж, 20.01 цагт жаргана. Тухайн өдөр үхэр, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр хууль цааз гаргах, батлах, хэрэглэх, хулгай дээрмийг номхтох, гэмтнийг шийтгэх, мал адгуус номхруулах, хараал, жатхыг буцаах, газар лусын зан үйл хийх, өр барагдуулах, гэр бүрэхэд сайн. Ургаа мод таслах, газрын ам нээх зэрэг үйлд муу. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод баруун хойш мөрөө гаргавал зохистой. Модон хохимой өдөр.

ЗГМ: СУДОКУ

1					2				
	8	9	7						
3	4							1	5
		2	8	1	3	4			
			9	5	7	6	2		
5	3							8	7
		1	4	6					
2									9

3	6	9	8	7	2	5	4	1	
5	8	2	4	6	1	7	3	9	
1	7	4	3	9	5	6	2	8	
7	3	6	2	1	4	8	9	5	
8	2	5	7	3	9	4	1	6	
4	9	1	6	5	8	3	7	2	
6	5	3	1	2	7	9	8	4	
9	1	8	5	4	3	2	6	7	
2	4	7	9	8	6	1	5	3	



Mission: Impossible-Fallout
Хаана: Өргөө кино театр
Хэзээ: 2018.07.27-ноос
Тасалбарын үнэ: ₮ 8-15 мянга



"Together" тоглолт
Хаана: White Rock
Хэзээ: 2018.08.17-нд
Тасалбарын үнэ: ₮ 60 мянга



Sunrise after party
Хаана: Үндэсний соёл амралтын хүрээлэн
Хэзээ: 2018.08.17-ны 21.00 цагт
Үнэ: ₮ 20 мянга

ОНЦЛОХ ҮЗВЭР

Tropical Music Festival 2018



Монголын анхны "CHILL OUT: Tropical Music Festival 2018"-ыг Үндэсний Соёл Амралтын Хүрээлэн дэх "Хар Сувд" усан онгоцон дээр "ХАЙРЫГ ТҮГЭЭ" уриан дор зохион байгуулах гэж байна. Энэхүү хөгжмийн наадам нь галт бамбар, далайн эргийн торгон элсэн дээр бүжилгэх,

тайвшралын хөгжим зэрэг хамгийн таатай мэдрэмжийг төрүүлэх юм. Мөн reggae, hippie, chill, salsa, latin, mexico, twerk, fire drum зэрэг олон төрлийн хөгжмийн урсгалуудыг сонирхуулах аж. Tropical music хамгийн анх Карибын тэнгисээс үүдэлтэй


хэмээн үздэг. Уг хөгжим 1940-1950 онд Куба улсад үүссэн бөгөөд хөнгөн хэмнэл нь салса бүжигт илүү тохирдог аж. Энэхүү хөгжим нь 1960 оноос одоог хүртэл идэвхтэй хөгжиж байгаа хөгжмийн урсгалын нэг юм. Тасалбарын үнэ 20-50 мянган төгрөг. [ЗГМ]



"Хүчирхэг оюун ухаан" УСК
Хаана: "Тэнгис" кино театр
Хэзээ: 2018.08.03-наас
Тасалбарын үнэ: ₮ 8-12 мянга



Nostalgia тоглолт
Хаана: Улсын филармони
Хэзээ: 2018.09.14-нд
Тасалбарын үнэ: ₮ 20 мянга



"Чехийн хөгжмийн үдэш" тоглолт
Хаана: Улсын филармони
Хэзээ: 2018.10.26
Тасалбарын үнэ: ₮ 25 мянга

ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ

1		2		3		4			5		6
		7			8		9				
10										11	
		12	13						14		
		15									16
		17									

БОСООГООР:

- Бөхийн мэх
- Халуун орны үзэсгэлэнт шувуу
- Олимпын төрөлд багтдаг зэвсэгт тулааны спорт
- Улиралд гурван удаа тохиох хугацааны нэр
- Дагаж, мөрдөх цааз, журам
- Өмнөговь аймгийн сум
- Ааш ааль
- Жалга
- Орон гүрэн
- Говийн тэнгэр (бурхад)
- Биеийн төлөөний үг
- Сарьдаг

ХӨНДЛӨНГӨӨР:

- Чингис хаант Монгол Улсын төрийн дуулал
- Онгон тал
- Амь ахуй

- Төв аймгийн сум
- Эрдмийн өргөө
- 10000 жилийн өмнө манай орны бүхий л нутгаар олноор амьдарч асан үслэг биетэй том амьтан

Д	А	Л	И	У	Т	О	Х	О	М	
А	А			Б		Э			Э	
М	О	Л	О	Р	Э	Р	Д	Э	Н	Э
Д			Й		Р	Э			Р	
И	Д	Э	Р		С		Ү	Н	Э	Э
Н	Х		Ө		Ү		Б		Э	
Д	О	Н	Д	О	Г	М	А	А		

Өмнөх дугаарын харуул / 08.16



RENAULT
Passion for life

ШИНЭ ЗАГВАРЫН РЕНО КАПТУР

Францын автомашин үйлдвэрийн тэргүүлэгч Рено компанийн анхны 30 шинэ автомашин Монголд буулаа. Тус загварын автомашиныг Монголд борлуулах албан ёсны төлөөлөгчөөр "Моннис моторс" компани хамтран ажиллаж байгаа бөгөөд өчигдөр шинэ төмөр хүлгийн эздэд түлхүүрийг нь гардуулж өгсөн юм.

Энэхүү автомашины бусдаас ялгарах онцлог нь хямд үнэ, өндөр чанар юм. Мөн худалдан авагч бүртээ 100,000 буюу гурван жилийн баталгаа өгөх бөгөөд энэ хугацаанд "Моннис моторс" компани засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгслээр бүрэн хангах юм.

Монгол Улсад жилд 50 гаруй мянган автомашин импортоор орж ирдэг. Үүний 95 хувь нь хуучин, үлдсэн таван хувь нь шинэ. Шинээр орж ирж буй таван хувийг тоогоор авч үзвэл 2000 гаруй автомашин юм. Үүний ихэнх нь том оврын жийп байдаг.

Учир нь монголчууд шинэ суудлын автомашин 60 сая төгрөгөөр авснаас хуучин жийп авахыг илүүд үздэг. Тэгвэл Рено компанийн шинэ автомашины үнэ 33 сая төгрөгөөс эхэлж буй хэмээн "Моннис моторс" компанийн ТУЗ-ийн гишүүн П.Баяр хэллээ.

